Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд суурь судалгааны төслийн санхүүжилтэд 140,043.3 мянган, Хүрээлэнгийн судлаачдын гаргасан ном бүтээлийн борлуулалтын орлогоос 5,555.3 мянган, угсаатны зүйг авран хамгаалах, суурь судалгааны ажлын 80,474.8 мянган, нийт 226,247.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 96,682.3 мянган, цалин нэмэгдэл, НДШ-ийн зардалд 41,380.6 мянган, хангамж бараа материалын зардалд 17,895.5 мянган, томилолтын зардалд 19,447.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,282.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 49,559.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 48,936.2 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 153.7 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.2 хувийн биелэлттэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Хүснэгт 2. Үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
24.5	Код	Нэр				
1	24.5.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	13.6	13.6	-	100.0
2	24.5.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	60	130	(70)	216.7
3	24.5.3	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	18	26	(8)	144.4
Дундаж хувь						153.7

3.8 Аудитын гол асуудал

Дээд шатны төсөв захирагчаас тайлант хугацааны эцэст хэрэгжээгүй байгаа ажлын зардалд санхүүжилт өгөх, зардлын эрх олгох, төсвийн бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж байгаа зэргийг цаашид анхаарах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Түүх, угсаатны зүйн хүрээлэн тайлант онд нийт 1,476,728.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 10 мэдээллийг ил тод байршуулаагүй, 292,395.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хурал зөвлөгөөн зохион байгуулж 18,639.7 мянган төгрөгийн зардал гаргаж үдийн хоол, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх”, 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй тул албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, хурал зөвлөгөөн зохион байгуулсан нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.5, 1.6 заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 363,438.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 294,621.4 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 18 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 зөвлөмжийн биелэлт 70 хувь, 3,200.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	3,200.5	2	3,200.5	-	-	85.0
Нийт дүн	2	3,200.5	2	3,200.5	-	-	85.0

Цахим татварын системд худалдан авалтуудыг бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлж шилэн дансны цахим системд мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших зөвлөмжийн зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацааны эцэст үүссэн авлага дансны үлдэгдэл, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 196,803.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 11,250.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 68,950.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 116,602.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 196,803.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 184,151.3 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.2 Төлбөрийн акт

Нэр бүхий 20 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан 6,310.8 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар", -ын 2-д "Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, ээлжийн амралтын тооцооллыг улирал тутамд хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх. Төлбөрийн акт тогтоох.

Анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахуун авсан баримт, жолоочийн замын хуудасгүй 4,940.0 мянган төгрөгийн шатахуун талоныг зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүрдэл хангасан анхан шатны баримтаар гүйлгээ хийж зардлаар бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх. Төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

Төсвийн зарцуулаагүй үлдэгдлээс оны эцэст худалдан авалтын гэрээ байгуулж 27,965.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны авлагын тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх.

Байгууллагын нярвын дансанд 12 дугаар сарын 24, 30-ны өдрүүдэд нийт 40,985.0 мянган төгрөгийн шилжүүлж урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн данснаас тайлант хугацааны эцэст зарцуулаагүй үлдсэн зардлыг улсын төсөвт төвлөрүүлэн авлагаар тусгаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд 57,525.8 мянган төгрөгийн номыг нэр төрлөөр бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн тооллогыг дахин явуулж номыг нэр төрөл, тоо ширхгээр задалж бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст 8,659.8 мянган төгрөгийн шатахуун талоны худалдан авалт хийж түлш, шатах тослох материалын дансанд 11,916.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант хугацааны эцэст хэмнэлт үүсэх боломжтой зардлыг гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэс буюу 12 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд 47,159.5 мянган төгрөгийн ном хэвлүүлэх, өрөөний камер суурилуулалтын зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааг зөв төлөвлөх төсвийн хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Нэр бүхий 20 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан 6,310.8 мянган төгрөгийг олгосон	Цалин, ээлжийн амралтын тооцооллыг улирал тутамд хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх. Төлбөрийн акт тогтоох.	1	6,310.8			1	6,310.8						
2	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахуун авсан баримт, жолоочийн замын хуудасгүй шатахуун талоныг зардлаар бүртгэсэн	Бүрдэл хангасан анхан шатны баримтаар гүйлгээ хийж зардлаар бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх. Төлбөрийн акт тогтоох.	1	4,940.0			1	4,940.0						
3	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Байгууллагын нярвын хувийн дансанд 12 дугаар сарын 24, 30-ны өдрүүдэд нийт 40,985.0 мянган төгрөгийн шилжүүлэг хийж Урьдчилгаа дансанд бүртгэсэн	Нэмэлт санхүүжилтийн данснаас тайлант хугацааны эцэст зарцуулаагүй үлдсэн зардлыг улсын төсөвт төвлөрүүлэн авлагаар тусгаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх.	1	40,985.0					1	40,985.0				
4	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацааны эцэст худалдан авалтын гэрээ байгуулж 27,965.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.	Дансны авлагын тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх.	1	27,965.0					1	27,965.0				
5	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дансанд 57,525.8 мянган төгрөгийн номыг нэр төрлөөр бүртгээгүй	Үндсэн хөрөнгийн тооллогыг дахин явуулж номыг нэр төрөл, тоо ширхгээр задалж бүртгэх	1	57,525.8								1.0	57,525.8	

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

				зөрчлийг давтан гаргахгүй байх												
6	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацааны эцэст 8,659.8 мянган төгрөгийн шатахуун талоны худалдан авалт хийж түлш, шатах тослох материалын дансанд 11,916.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан	Тайлант хугацааны эцэст хэмнэлт үүсэх боломжтой зардлыг гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	11,916.9								1	11,916.9	
7	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацааны эцэс буюу 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд 47,159.5 мянган төгрөгийн ном хэвлүүлэх зардал, өрөөний камер суурилуулалтын зардал гаргасан	Үйл ажиллагааг зөв төлөвлөх төсвийн хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	47,159.5								1	47,159.5	
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					7	196,803.0	-	-	2	11,250.8	2	68,950.0	-	-	3	116,602.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	14 мэдээллийг ил тод байршуулаагүй, 292,395.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардага өгөх.	1	292,395.0					1	292,395.0				
2	ШАУ-ТУЗХ	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	Хурал зөвлөгөөн зохион байгуулан 18,639.7 мянган төгрөгийн зардал гаргаж үдийн хоол, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй тул албан шаардлага өгөх.	1	18,639.7					1	18,639.7				
Нийцлийн аудитын дүн					2	311,034.7	-	-	-	-	2	311,034.7	-	-	-	-
Нийт дүн					9	507,837.7	-	-	2	11,250.8	4	379,984.7	-	-	3	116,602.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 08/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/60/НА-СТЯ-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 20 ажилтанд цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулж 6,310,800.00 (зургаан сая гурван зуун арван мянга найман зуун) төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Эрүүл мэнд нийгэм хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 13 "Ажил олгогч нь ажилтан ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлүүлээгүй амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 6,310,800.00 (зургаан сая гурван зуун арван мянга найман зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\hcnig_kherag\Akt\2022\0225 Auditin 1 Gamr-12.Docx

001030050



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 29/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/60/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримт, жолоочийн замын хуудасгүй 4,940,000.00 (дөрвөн сая есөн зуун дөчин мянган) төгрөгийг зардлаар бүртгэсэн;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй бүртгэсэн 4,940,000.00 (дөрвөн сая есөн зуун дөчин мянган) төгрөгийг тус тус буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэхийг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 202/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/60/НН-СТН-ТЧЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нярвын дансанд 12 дугаар сард нийт 40,985,000,00 (дөчин сая есөн зуун наян таван мянган) төгрөгийн шилжүүлж урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" тогтоолын 3.1. "Төсвийн тухай хуулийн 7.7, 44.6-г үндэслэн төсвийн жил дуусахад улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг улсын төсвийн дансанд, орон нутгийн төсвийн байгууллагын үлдэгдлийг тухайн орон нутгийн төсвийн дансанд, нийгмийн даатгалын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг нийгмийн даатгалын сангийн төсвийн дансанд оны сүүлийн ажлын өдрийн банк хоорондын сүлжээгээр хамгийн сүүлийн орлого татсаны дараа төрийн сангууд шууд татан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст дэмжих баримтгүй хувийн дансанд шилжүүлэхгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264730

110.10.10.20\Michig_Kharag\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-200.Docx

0010800644



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 35/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 2022/60/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны эцэст худалдан авалтын гэрээ байгуулж 27,965,000.00 (хорин долоон сая есөн зуун жаран таван мянган) төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтаны албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ийн ЗАХИРАЛ,
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
Б СЭРЖМЯДАГ
Ч МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 201/А.0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/60/МХ-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, ил тод байршуулах 10 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 205/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/60/НА-ЦТЛ-ТЧУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хурал, зөвлөгөөн зохион байгуулж 18,639,700.00 төгрөгийн зардал гаргаж үдийн хоол бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.6.Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА



